

“Салбар, орон нутгийн хөгжлийн жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, үйл ажиллагаа” техникийн туслалцааны төслийн хүрээнд  
Сэлэнгэ аймагт ажилласан тайлан

2017-05-11

ХНХЯ, АХБ-тай хамтран хэрэгжүүлж байгаа “Салбар, орон нутгийн хөгжлийн жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, үйл ажиллагаа” техникийн туслалцааны төслийн хүрээнд ХНХЯ-ны Жендэрийн үндэсний хорооны ажлын албаны дарга Т.Энхбаяр, холбогдох мэргэжилтнүүдийн хамт 2017 оны 5 дугаар сарын 8-10-ны өдрүүдэд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотод батлагдсан удирдамжийн дагуу ажиллаа. Энэ хүрээнд Сэлэнгэ аймгийн ЗДТГ болон техникийн туслалцааны төслийн жендэрийн зөвлөх багийн гишүүн, жендэрийн зөвлөх Т.Амгалан, Б.Онон, О.Оюунцэцэг нартай хамтран нийт 4 удаагийн сургалтыг зохион байгуулж, орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөр боловсруулах ажлыг эхлүүллээ. Дээрх арга хэмжээнд аймгийн ИТХ-ын дарга Г.Бямбаа, Засаг дарга Ш.Оргил болон аймгийн газар, хэлтсийн дарга, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл нийт 98 хүн хамрагдлаа.

Зохион байгуулсан сургалт, семинар:

1. Орон нутгийн удирдлага, жендэрийн салбар хорооны гишүүдэд жендэрийн үндсэн ойлголт, жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний тогтолцоо, эрх зүй бодлогын орчин сэдвээр сургалт зохион байгуулж, 30 хүн хамрагдав.
2. Аймгийн жендэрийн дэд хөтөлбөр боловсруулж, батлуулах ажлын хэсгийн гишүүдэд орон нутгийн жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр боловсруулах үйл явц, үндэсний бодлогын уялдаа, дэд хөтөлбөр боловсруулах ажлын төлөвлөгөөний талаар сургалт зохион байгуулж, 12 хүн хамрагдав.
3. Орон нутгийн иргэний нийгмийн байгууллагын ажилтнуудад жендэрийн асуудлаар мэдээлэл хийж, дэд хөтөлбөрийг боловсруулах явцад хэрхэн оролцох талаар сургалт зохион байгуулж, 9 хүн хамрагдав.
4. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын жендэрийн бодлогыг боловсруулах ажлын хүрээнд орон нутгийн холбогдох байгууллагуудын удирдлага, мэргэжилтнүүд нийт 47 хүнийг хамруулсан сургалт, семинар зохион байгуулж, боловсрол, соёл, биеийн тамирын салбар дахь тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцлээ.

Сэлэнгэ аймагт ажилласан талаарх холбогдох мэдээг бэлтгэн, ЖҮХ-ны фэйсбүүк хуудсанд байрлуулсан.

ХНХЯ-ны ЖҮХАА-ны дарга Т.Энхбаяр орон нутгийн телевизэд төслийн зорилго, хүлээгдэж буй үр дүнгийн талаар яриа, мэдээлэл хийсэн.

